



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/109

Сүхбаатар сум

Хяналтын цэг ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.1.3 "г", "н", 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2, 16.2.4, 16.2.10, Газрын хэвлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.16, 17.2.20, 17.2.21, Ашигт малтмалын тухай хуулийн 12.1.1, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.6, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 37 дугаар зүйлийн 37.1, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоол Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 8 дугаар зүйлийн 8.1.1, 2018 оны 318 дугаар тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, Улсын Онцгой комиссын 2020 оны "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 тоот албан даалгавар, Засгийн газрын "Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2020 оны 30 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай" тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ойн сан бүхий Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Ерөө, Мандал, Түшиг, Хүдэр, Хушаат, Цагааннуур зэрэг сумдын нутагт ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын цэгийг 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэл, хууль бусаар ашигт малтмал олборлох, мод бэлтгэхээс урьдчилан сэргийлэх хяналтын цэгийг Жавхланта сумын нутаг Сүхбаатар-Дархан /А0402/ чиглэлийн замаас Жавхланта сум салдаг хэсгүүдэд 2020 оны 04 дугаар сарын 06-ны өдрөөс 07 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл тус тус байнгын ажиллагаатай хяналтын цэгүүдийг ажиллуулсугай.

2. Дээрх хяналтын цэгүүдэд ажиллах томилгоот бүлгийн ажиллах байршлыг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хяналтын цэгт Онцгой байдлын газартай хамтран ажиллах бүрэлдэхүүнийг сумын болон сум дундын ойн анги, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагуудаас томилон ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт, цагдаагийн албан хаагч томилон ажиллуулахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа /А.Энхбат/-д, хил дамнасан түймрээс

урьдчилан сэргийлэх, гарсан түймрийг шуурхай унтраах ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Хилийн цэргийн 0243 дугаар ангийн захирагч, хурандаа /Б.Гантөмөр/-д тус тус үүрэг болгосугай.

4. Сум орон нутгийн хэмжээнд "COVID-19" вирусийн болзошгүй эрсдэлээс томилгоот бүлгийн бүрэлдэхүүнийг урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөц бүрдүүлсэн байх, хяналтын цэгт ажиллах иргэдээс халдварт өвчний тандалт судалгаа авч ажиллуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Дээрх хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг бүх талаар дэмжин ажиллах албан хаагчдыг байр, сууц, тээврийн хэрэгсэл болон үүрэг гүйцэтгэх нөхцөлөөр хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

6. Хяналтын цэгүүдийн үйл ажиллагааны зардалд шаардагдах нийт **43,441,270** /дөчин гурван сая дөрвөн зуун дөчин нэгэн мянга хоёр зуун далан/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

7. Захирамжийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч ажиллан, ажлын явц үр дүнгийн талаар аймгийн Засаг даргын зөвлөлд 14 хоног тутамд танилцуулж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /З.Түвшинтөгс/, Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа /А.Энхбат/, Онцгой байдлын газрын дарга, хурандаа /Г.Баатар/, Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/ нарт тус тус үүрэг болгосугай.

8. Захирамжийн хэрэгжилтэд хяналт авьж, үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч, Ой, хээрийг түймрээс хамгаалах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дарга /Ж.Сайнцог/- д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  ШОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 04 сарын 02 -ны өдрийн
А/109 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

**Нэг. ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХУУЛЬ БУСААР
АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ, МОД БЭЛТГЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
БҮЛЭГ АЖИЛЛАХ ХУВААРЬ**

Нэг. Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, сумдын ЗДТГазар:

№	Сумдын нэр	Газар нутгийн нэр	Бүлэгт ажиллах хүний тоо			Машин техникийн Тоо
			БОАЖГ, Сумын ЗДТГ	ОБГ-аас	Цагдаагийн газар	
1	Алтанбулаг	Хутаг өндөр	1	1	1	-
2	Баянгол	Наран	1	1	1	-
3	Баруунбүрэн	Бургалтай	1	1	1	-
		Амарбаясгалант, Эвэн	1	1	1	-
4	Ерөө	Япон толгой, Яргайт, Буулиаст	1	1	1	1
		Бугант тосгон, Их алт, 35-ын ам	1	1	1	1
5	Түшиг	Жаргалант, Хар горхи	1	1	1	1
		Улаан овоот, Зэлтэр гүүр	1	1	1	1
6	Хүдэр	Нүхэн гүүр	1	1	1	1
		Унаган толгой	1	1	1	1
7	Хушаат	Ар тойлбо	1	1	1	1
8	Цагааннуур	Согооч	1	1	1	1
9	Мандал	Бар чулуут	1	1	1	1
		Ар гахайт	1	1	1	1